

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨСӨВ  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ №05

2024 оны 08 дугаар сарын 02

Налайх дүүрэг

Налайх дүүргийн ИТХ-ын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны 05 дугаар хуралдаан 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 15:00 цагаас ирвэл зохих 7 Төлөөлөгчөөс 5 оролцож, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаж, “Налайх дүүргийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцээд дараах санал дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1. Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 10 шар хүртэлх зам засварын ажилд зарцуулагдах 1,020,000,000 /нэг тэрбум хорин зургаан сая/ төгрөг бүхий төсвийг, дүүргийн онцгой комиссын хуралдаанаар “шар түвшинд” шилжүүлсэн тул Засаг даргын нөөц хөрөнгөд шилжүүлэн өөрчлөлт оруулж, батлагдсан зураг төсвийн дагуу хэсэгчилсэн байдлаар стандартад нийцүүлэн, тоо хэмжээг нэмэгдүүлэн далан шуудууг хийж гүйцэтгэх;
2. Өмнөх оны төсвийн үлдэгдэл хөрөнгөөс 67,000,000 /жаран долоон сая/ төгрөгийг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн урд замаас 51 дүгээр байр хүртэлх авто замыг нөхөх ажилд зарцуулах;
3. 8 дугаар хорооны 60-61 дүгээр байрны ар талд байрлах “Гар бөмбөг”-ийн талбай хийх 16,500,000 төгрөгийг үерт автсан байршлуудыг нөхөн сэргээх, ариутгах ажилд зарцуулахаар өөрчлөлт оруулах

Дүгнэлт: Налайх дүүргийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд хуралдаанд оролцсон хөгжлийн хорооны гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 38 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.

ХЯНАСАН:  
ХУРЛЫН ХОРООНЫ ДАРГА С.ЯЛАЛТ

САНАЛ ДҮГНЭЛТ НЭГТГЭСЭН:  
ХУРЛЫН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Б.Амарбаяр* Б.АМАРБАЯР

